



## БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/199

Улаанбаатар хот

### Хариуцлагатай эргүүл, жижүүр томилон ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", 29.2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.8, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тулгар төрийн 2226, Их Монгол Улсын 811, Ардын хувьсгалын 96 жилийн ойн баяр наадмын өдрүүдэд ажиллах дүүргийн хариуцлагатай эргүүл, жижүүрийн хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Хариуцлагатай эргүүл, жижүүрийн үүргийг тогтоосон хугацаанд зохих журмын дагуу гүйцэтгэж хороод, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжүүдтэй байнгын холбоо тогтоон, шаардлагатай арга хэмжээг шуурхай зохион байгуулж, Нийслэлийн хариуцлагатай жижүүрт 2 цаг тутамд мэдээлэл өгч ажиллахыг эргүүл, жижүүрээр томилогдсон ажилтнуудад үүрэг болгосугай.

3. Баярын өдрүүдэд ажлын байрныхаа аюулгүй байдлыг хангаж, шаардлага гарвал дүүргийн хариуцлагатай жижүүрт байдлыг мэдэгдэж ажиллахыг харъяа байгууллага, хэлтэс, албадын дарга, хороодын Засаг дарга нарт даалгасугай.

4. Эргүүл жижүүрийг шаардлагатай мэдээллээр ханган, ажил үүргийн хэрэгжилтэд хяналт тавьж, баярын өдрүүдэд хэрхэн ажилласан талаарх илтгэх хуудсыг 2017 оны 07 дугаар сарын 17-ны өдөр гарган танилцуулахыг Онцгой байдлын хэлтэс /Л.Цэрэндаваа/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВДАВАА